



**ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/50

Бэрх

**Хяналт, шалгалт хийх
ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8 дах заалт, Хэнтий аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 03/317 тоот албан бичгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хүнс, хөдөө аж ахуйн улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/030 дугаартай удирдамжийн дагуу тус хотын худалдаа, үйлчилгээ эрхлэгч байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 09 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Ганцэцэг /ЗАА-ны ХХАА-н мэргэжилтэн/

Гишүүд:

Б.Болорцэцэг /Татварын улсын байцаагч/

Т.Очирбат /Газрын даамал /

Н.Мичидмаа /Дотоод ажил мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн/

Б.Соёл-Эрдэнэ /Архив, бичиг хэргийн эрхлэгч/

2. Заагдсан хугацаанд хяналтыг чанартай зохион байгуулж, дүн мэдээг Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга /Э.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН